



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5² дугаар зүйлийн 5².1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1267, А/1292 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1267, А/1292 дугаар захирамжийн дагуу авто үйлчилгээ, хоёрдогч түүхий эд худалдан авах цэг, барилгын материалын худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх албан хаагчдын хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллахыг эрх бүхий албан тушаалтнуудад, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс (Б.Найрамдал), Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс (Г.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3.Удирдамжийн дагуу илүү цагаар ажиллах нөхцөлд холбогдох дүрэм, журмын дагуу илүү цагийн тооцоог хянаж олгохыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ